



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

2024 оны 04 дүгээр сарын 23
№16 (1312)

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР



ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

226.	Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	703
------	---	-----

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

227.	Хянан шалгах түр хороо байгуулах тухай	Дугаар 25	704
------	---	-----------	-----



᠘᠘᠒.	ᠰᠢᠨᠠᠨᠠᠭᠤᠨ ᠰᠢᠨᠠᠨᠠᠭᠤᠨ ᠰᠢᠨᠠᠨᠠᠭᠤᠨ Mongol Folio_ ᠔2 Yekil Horok ᠔2 Doodlogok	᠘᠘	᠒᠐᠒
᠘᠘᠑.	ᠰᠢᠨᠠᠨᠠᠭᠤᠨ ᠰᠢᠨᠠᠨᠠᠭᠤᠨ ᠰᠢᠨᠠᠨᠠᠭᠤᠨ Mongol Folio_ ᠔2 Hail		᠒᠐᠕

ᠰᠢᠨᠠᠨᠠᠭᠤᠨ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 04 дүгээр
сарын 12-ны өдөр

Дугаар 25

Улаанбаатар
хот

Хянан шалгах түр хороо байгуулах тухай

Хуулийн этгээдэд хууль тогтоомжид заасны дагуу ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг олгосон, зохих төлбөр, татвар ногдуулсан, хураасан эсэхийг шалгах шаардлагыг харгалзан Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэг, Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 8 дахь заалт, Хорин наймдугаар зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсэг, 34 дүгээр зүйлийн 34.1, 34.2, 34.3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Улсын Их Хурлын хянан шалгах түр хорооны шалгалтын сэдвийг “Ашигт малтмал хайх, ашиглах зориулалтаар газар, түүний хэвлийг тусгай зөвшөөрлөөр олгох, төлбөр, татвар ногдуулах, хураахтай холбоотой үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх”-ээр тогтоосугай.

2.Улсын Их Хурлын хянан шалгах түр хорооны тусгай шалгалтын хүрээ хязгаарыг доор дурдсанаар тогтоосугай:

1/ашигт малтмал хайх, ашиглах зориулалтаар газар, түүний хэвлийг тусгай зөвшөөрлөөр олгох үйл ажиллагаа;

2/ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчийг бүртгэх үйл ажиллагаа;

3/тусгай зөвшөөрлөөр олгосон газар, түүний хэвлийг зориулалтын дагуу ашиглаж байгаа эсэх;

4/ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчид төлбөр, татвар ногдуулах, тайлагнах, төлөх, хянах, хураах үйл ажиллагаа.

3.Улсын Их Хурлын хянан шалгах түр хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:



Олонхыг төлөөлж:

Ц.Сандаг-Очир

Улсын Их Хурлын гишүүн

Ц.Цэрэнпунцаг

Улсын Их Хурлын гишүүн

Б.Энх-Амгалан

Улсын Их Хурлын гишүүн

Цөөнхийг төлөөлж:

Ш.Адьяашаа

Улсын Их Хурлын гишүүн

Т.Доржханд

Улсын Их Хурлын гишүүн

4.Хяналт шалгалтын тайлан, санал, дүгнэлтийг Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд Улсын Их Хуралд танилцуулахыг Хянан шалгах түр хороонд даалгасугай.

5.Энэ тогтоолыг 2024 оны 04 дүгээр сарын 12-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР



Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medeel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 0.5

Индекс: 200003